



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 9/с1

Эрдэнэт

Аймгийн боловсролын салбарыг 2017-2020 онд
хөгжүүлэх дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 "а", 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Аймгийн боловсролын салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх дэд хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2.Аймгийн Засаг дарга Д.Батлутад ДААЛГАХ нь:

2.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг гаргаж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулах.

2.2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусгах, олон улсын байгууллагын төсөл, хандив, тусламжинд хамруулах арга хэмжээ авах.

2.3.Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн 2 дугаар сард аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд тайлагнаж байх.



ДАРГА

П.ПҮРЭВЛХАГВА